

**“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР”-ЫН 2022, 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2023.04.03

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Аймгийн засаг даргын Дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан санхүүгийн хяналт шалгалтын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм нормативын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Шалгалтыг Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Бархасмаа, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Батсайхан нар санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, хяналт шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 27-ноос ажлын 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. ХАМРАГДСАН АСУУДАЛ

Шалгалтыг 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтанд тулгуурлан төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн.

Үүнд:

1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл тухайн байгууллагатай холбоотой хууль, тогтоомж, дүрэм журам, хамтын гэрээ, үйл ажиллагаандаа мөрдөж буй бусад эрхийн актын хэрэгжилт.
2. 2022, 2023 оны 3 дугаар сар хүртлэх төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын байдал.
3. Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалтын байдал
4. Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн баримтийн бүрдүүлэлт, зарцуулалт тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал
5. худалдан авах үйл ажиллагаа
6. Ажиллагсадын цалин тогтоомж, тооцоололт, олголтын баримтын бүрдэл
7. Өмч хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тооллого, тооцоо бодолт.
8. Өр авлагын барагдуулалт үүссэн өр авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал
9. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал
10. Өмнө хийгдсэн шалгалтын зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын тайлан, төлбөр барагдуулалтын байдал
11. Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг үндсэн баримт материалтай нь тулган шалгах.

ДӨРӨВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төрийн аудитын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан; “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн байна. Дараах зөрчилд Албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн байна.

1. 3,419.0 төгрөгийн анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зөрчилд зөвлөмж.
2. 26,072.1 мянган төгрөгийн үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийг акталж устгаагүй, дахин үнэлэхээр арга хэмжээ аваагүй зөрчилд зөвлөмж.
3. 3,992.7 мянган төгрөгийн цалингийн урамшуулалаас нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвар суутгаагүй 958.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага.
4. Худалдан авах ажиллагаанд оролцсон гэрээт ажилчдад 562.8 мянган төгрөгийн хөлс олгосон боловч нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй 135.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага.
5. Шилэн дансны 6 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл байршуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

ТАВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх, бүртгэл тооцоог байгууллага бүрээр хөтлөн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод, шудрага болгож хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг хангаж ажиллах зорилтыг тавин ажиллаж байна.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.4.18-д заасны дагуу 2022, 2023 оны санхүүгийн баримтанд нэг, хоёр дугаар гарын үсгийн дараах албан хаагчид зурсан байна.

Байгууллагын нэр	Хугацаа	1-р гарын үсэг	2-р гарын үсэг
ОНӨГазар	2022.01.01-2022.06.20	Ж.Гантулга	Э.Саранзаяа
	2022.06.20-2022.09.30	Б.Адъяасүрэн	
	2022.10.01-2022.10.31	С.Ууганбаяр	
	2022.11.01-2022.12.31	Б.Адъяасүрэн	

ЗУРГАА: ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 13.1-д байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дотоод хяналт шалгалтын журам тогтоож ажиллана, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 67.1-д төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 18-р зүйлд нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар заасан заалтын дагуу

дотоод хяналтын нэгжийг байгууна, Засгийн газрын 311 дүгээр тогтоолын дагуу хяналт шалгалтын нэгж байгуулж ажиллаагүй байна.

ДОЛОО. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2022 оны санхүүгийн тайлангаар:

Орон нутгийн төсвөөс 125,568.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 5,600.0 мянган төгрөг, дээд шатнаас хувиарлсан 9,649.4 мянган төгрөг, нэмэлтээр 15,249.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 140.0 мянган төгрөгийн орлого олж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

2022 онд төсвөөс 125,568.8 мянган төгрөг олгосоноос 123,347.6 мянган төгрөгийг зарцуулж 2,361.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Байгууллагын үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 72,133.9 төгрөг, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 13,439.8 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 2,342.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авч 5,845.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталж устгасан байна. Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 35,786.5 мянган төгрөг.

Үзүүлэлт	Барилга	Тээвэр	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	Дүн
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	5,843,610	20,990,200	37,852,288	5,839,876	300,000	1,308,000	72,133,975
Нэмэгдсэн			15,781,874				15,781,874
Худалдан авсан			13,439,839				13,439,839
Хандиваар							
Шилжүүлэн авсан							
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр							
Бусад			2,342,035				2,342,035
Дахин үнэлгээний нэмэгдэл							
Хасагдсан			3,148,402	2,696,935			5,845,338
Худалдсан							
Акталсан			2,568,402	80,000			2,648,402
Шилжүүлсэн			580,000	2,616,935			3,196,935
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр							
Бусад							
Дахин үнэлгээний хорогдол							
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ (IV=I+II-III)	5,843,610	20,990,200	50,485,760	3,142,941	300,000	1,308,000	82,070,511
Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	1,753,083	17,783,364	15,057,234	3,085,221	180,000		37,858,903

Өмнөх оны элэгдлийн зөрүү							
Зардал	584,361	3,206,835	8,108,614	1,027,476	60,000		12,987,288
Элэгдлийн зардал тайлант хугацааны	584,361	3,206,835	8,108,614	1,027,476	60,000		12,987,288
Элэгдлийн зардал Бусад							
Дансны хасалт			2,509,781	2,052,486			4,562,268
Бусад			2,509,781	2,052,486			4,562,268
Дахин үнэлгээний							
Үзүүлэлт	Барилга	Тээвэр	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	Дүн
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЛИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ (X=VI+VII-IX)	2,337,444	20,990,200	20,656,067	2,060,210	240,000		46,283,922
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ (XI=IV-X)	3,506,166		29,829,692	1,082,730	60,000	1,308,000	35,786,588

Бараа материалын талаар:

Бараа материал 68.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.

Код	Үзүүлэлт	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш, шатах тослох материал	Барилгын засварын материал	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	1,936,420	2,906,952			482,600	5,325,972
2	Нэмэгдсэн	2,818,200	1,985,750	660,000	3,335,644		8,799,594
201	Худалдан авсан	2,818,200	1,985,750	660,000	3,335,644		8,799,594
202	Хандиваар						
203	Шилжүүлэн авсан						
204	Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр						
205	Бусад						
3	Хасагдсан	2,832,120	1,420,500	660,000	3,335,644	482,600	8,730,864
301	Худалдсан, зарцуулсан	2,832,120	1,420,500	660,000	3,335,644	482,600	8,730,864
302	Шилжүүлсэн						
303	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр						
304	Бусад						
4	Эцсийн үлдэгдэл (IV=I+II-III)	1,922,500	3,472,202				5,394,702

Авлагын тайлангийн талаар:

2022 оны жилийн эхний байдлаар 1,004.9 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байсан ба жилийн эцэст 41.3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Цалингийн авлага өсч, байгууллагаас авах авлага буурсан үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
НИЙТ	1,004,957.00	1,442,880.00	1,401,500.00	1,046,337.00
АВЛАГА	1,004,957.00	542,880.00	501,500.00	1,046,337.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,003,457.00	542,880.00	500,000.00	1,046,337.00
Цалингийн авлага	1,003,457.00	542,880.00	500,000.00	1,046,337.00
Бусад авлага	1,500.00		1,500.00	
Байгууллагаас авах авлага	1,500.00		1,500.00	
УРЬДЧИЛГАА		900,000.00	900,000.00	
Бусад урьдчилгаа		900,000.00	900,000.00	
Урьдчилгаа тооцоо		900,000.00	900,000.00	
Цалингийн урьдчилгаа		900,000.00	900,000.00	

Өглөгийн тайлангийн талаар:

2022 оны жилийн санхүүгийн тайлангаар өглөггүй гарсан байна:

НАЙМ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧИЛ

1. Байгууллагын дарга албан хаагчдадаа урамшуулал болон дэмжлэг үзүүлэхдээ өөрөө өөртөө тушаал гарган хавсралтаар олгосон. /2022 оны 09 сарын 22-ны А/08 тоот тушаалаар урамшуулал олгосон, 2022 оны 12 дугаар сарын 21-ны А/17 тоот тушаалаар албан хаагчдад дэмжлэг үзүүлсэн/
2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгж байгуулаагүй байна.
3. 1,046.3 төгрөгийн авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй

ЕС: ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар хяналт хийхэд 2022 оны шилэн дансны сайдад 6 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээллийг байршуулаагүй биелэлт 99 %-тай гарсан байна.

Мөн 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхлэсэн шинэчилсэн шилэн дансанд бүртгүүлж мэдээллээ иж бүрэн байршуулсан байна.

АРАВ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Шалгалтын удирдамжийг танилцуулж, шалгалтыг холбогдох үндсэн баримтанд тулгуурлан явуулж, зөрчилтэй зүйлүүдэд тухай бүр нь хууль, тогтоомжийн үндэслэлийг нь тайлбарлан зөвлөн туслав.

АРВАН НЭГ. ШАЛГАЛТААР ӨГСӨН ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулан байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн, санхүүгийн программ ашиглан нягтлан бодох бүртгэлийг хөтөлж хууль тогтоомж, УСНББОУСтандартыг мөрдөн ажилласан байна.

Орон нутгийн худалдан авах ажиллагаа шалгалтын явцад хийгдээгүй болно.

АРВАН ХОЁР. ШАЛГАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ

1. Байгууллагын дарга өөртөө хамааралтай хөрөнгө, санхүүтэй холбоотой шийдвэр гаргахдаа дээд шатнаас зөвшөөрсөн шийдвэрийг үндэслэх.
2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгж байгуулах.
3. Хувь хүнээс авах 1,046.3 мянган төгрөгийн цалингийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан тоотоор хариу ирүүлэх.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ  С.БАРХАСМАА

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Б.БАТСАЙХАН

ТАНИЛЦСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АДЪЯАСҮРЭН

НЯГТЛАН БОДОГЧ:  Э.САРАНЗАЯА

